



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/61

Сант сум

Газрын дуудлага худалдааны

комисс томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны "Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 54 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэхээр заагдсан газруудад дуудлага худалдаа явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2.Дуудлага худалдааны комиссын дарга Б.Мөнх-эрдэнэ (Засаг даргын орлогч), дуудлага худалдааны хөтлөгч Ч.Азжаргал (Төрийн захиргаа, хууль эрх зүйн мэргэжилтэн), дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч Ц.Батсайхан (Газрын даамал).

3.Дуудлага худалдааны комиссын дарга (Б.Мөнх-эрдэнэ)-д даалгах нь:

3.1.Дуудлага худалдаа явуулах байр бэлтгэх, оролцогчдыг журмын дагуу бүртгэх.

3.2.Дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, ялагчийг үнэн зөв тодруулах.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *В. Догсайхан*  
Хянасан: *Ч. Агмарал*  
Хувь: *2*  
Огноо: *2023.04.24*